



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/463

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ажийн Болор" ХХК нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.7, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтуудад заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн (Д.Мягмарбаатар), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Мөнх-Эрдэнэ), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн (Б.Нандинбаатар) нарт олгож аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр (хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар) томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн (Д.Мягмарбаатар), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Мөнх-Эрдэнэ), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн (Б.Нандинбаатар) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.ЧОГСОМЖАВ